

**“БАЯНХОНГОР АЙМГИЙН “ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР”**

Огноо: 2020 оны 01 дүгээр сарын 28-ний өдөр



**АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН  
ХӨГЖЛИЙН ТӨВД 2020 ОНД ШААРДЛАГАТАЙ ХҮНСНИЙ МАТЕРИАЛ  
НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Гэрээний нэр, дугаар: Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудын хөгжлийн төвд 2020 онд шаардлагатай хүнсний материал: БХАОНӨГ/202012070

**2020 он**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА



**Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогдоос **Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд залуучуудыг хөгжүүлэх төвд 2020 онд шаардлагатай хоол хүнсний материал нийлүүлэх /БХАОНӨГ/202012070-ыг** нийлүүлэх тухай цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 / тавин мянган төгрөгийг/ цахим систем ашиглан төлсөн байх ёстай.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг [**2020 оны 02 дугаар сарын 03-ний өдрийн 10 цаг 00 минут**]-аас өмнө өөрийн аж ахуйн нэгжийн цахим гарын үсэг, хувийн нууцлалын кодоор [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад нэвтэрч цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг [**2020 оны 02 дугаар сарын 003-ний өдрийн [10 цаг 10 минут]**]-д аймгийн Орон нутгийн өмчийн газрын 115 тоот өрөөнд нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

[**Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газар**  
(нэг давхар, 115 тоот өрөө буюу 70443224 утсаар холбогдоно.)

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |  |   |
|--|---|
| 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | <p>1.1. Тендерт оролцогч нь "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид "ТШӨХ" гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p>  |
| 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт               | <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p> <p>2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.</p> |
| 3. Тендерийн иж бүрдэл                           | <p>3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</p> <p>(а) Үнийн санал;</p> <p>(б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;</p> <p>(в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;</p> <p>(г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;</p> <p>(д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]</p>  |
| 4. Тогтмол үнэ                                   | <p>4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</p>   |
| 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | <p>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.</p> <p>5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.</p>  |
| 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа           | <p>6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.</p>   |

- |  |  |
|--|--|
| 7. Санал<br>болжсон үнэ,<br>түүнийг үнэлэх           | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.<br><br>7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь <b>TШӨХ-д</b> заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.<br><br>7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болжсон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8. Гэрээ<br>байгуулах эрх<br>олгох тухай<br>мэдэгдэл | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.  |

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТӨӨЗ 1.1	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, залуучуудын хөгжлийн төвд 2020 онд шаардлагатай хоол хүнсний материалын нийт төсөв нь 19 сая төгрөг.</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үнийн санал маягтаар баталгаажуулан ирүүлэх</li> <li>2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг наториатоор баталгаажуулан ирүүлэх. /Үндсэн үйл ажиллагааны чиглэл нь хүнсний худалдаа эрхэлдэг байх/</li> <li>3. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурах этгээдийн итгэмжлэлийг маягтын дагуу гаргаж ирүүлнэ.</li> <li>4. Шүүхийн байгууллагаас сүүлийн 3 жилтэй холбогдох тодорхойлолт ирүүлэх</li> <li>5. Шүүхээр шийдвэрлэгдсэн өртэй эсэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт.</li> <li>6. Татварын хэлтсийн тодорхойлолт цахим тайлангаас ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан e-balance-aас тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана. Тендер нээсэн өдрийн байдлаар өртэй бол тус тендерээс татгалзах үндэслэл болно.</li> <li>7. Нийгмийн даатгалын байгууллагаас ямар нэгэн өр төлбөргүй ажилладаг тухай тодорхойлолт ирүүлэх.</li> <li>8. Урт хугацааны болон хугацаа хэтэрсэн зээлтэй эсэх талаар Монгол банкны тодорхойлолт эсхүл харилцагч бүх арилжааны банкны тодорхойлолт ирүүлэх.</li> <li>9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана./</li> <li>10. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл : Сүүлийн 1 жил буюу 2019 онд нийлүүлсэн ижил төстэй ажлын жагсаалт гаргаж гэрээ, актын хамт ирүүлнэ./ижил төстэй ажилд бараа нийлүүлж байсан туршлагыг тооцно/</li> <li>11. Сүүлийн 1 жил буюу 2018 оны санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Татварын ерөнхий газрын татвар төлөгчдийн мэдээллийн сан e-balance-aас тендерт оролцогчдын татвар төлөлт, санхүүгийн тайлангаас борлуулалтын орлого, шаардлагатай мэдээллийг шалгана.</li> <li>12. Сүүлийн 1 жил буюу 2019 онд батлагдсан төсөвт өртгийн 60 хувиас багагүй болон түүнээс дээш төгрөгийн ижил төстэй барааг доод тал нь нэг удаа нийлүүлсэн байна.</li> </ol> <p>Гэрээ болон бараа хүлээлгэж өгсөн актыг хавсарган ирүүлнэ.</p>
----------	---

13. Борлуулалтын хэмжээ: / 2018 он / Сүүлийн 1 жил буюу 2018 оны борлуулалтын орлогын дүн нь батлагдсан төсөвт өргийн 60 хувиас багагүй байх.

14. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгийн хэмжээ болон авах боломжит зээлийн хөрөнгийн нийт дүн батлагдсан төсөвт өргийн 50%-иас багагүй байх. Арилжааны банкны зээлийн авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт нь /Банкны судлан үзэж зээл олгох боломжтой эсхүл шаардлагатай материалыг үндэслэн гэсэн тодорхойлолтыг үнэлгээнд харгалзахгүй/ Судлагдсан зээлийн тодорхойлолт байх/

15. Тухайн бараа бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, машин механизмыг барааг нийлүүлэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Тоног төхөөрөмжийн нотлох баримт ирүүлэх.

16. *Барааг нийуулэх хугацааны график ирүүлэх.*

17. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд гэрээний үнэ, хугацаанд багтаан техникийн тодорхойлолтын дагуу чанарын өндөр түвшинд тухайн барааг нийлүүлэн хүлээлгэн өгөх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлнэ.

18. Тендерт шалгарсан тохиолдолд нийлүүлэгч нь өөрийн зардлаар барааг хүлээн авах газарт хүлээлгэн өгөхөө албан бичгээр гаргаж ирүүлэх.

19. Гэрээт хугацаанд нийлүүлэгдэх бүх бараа нь эрүүл ахуйн ахуйн стандарт шаардлага хангасан байх ба тээвэрлэлтийн үеийн гэмтэл согог гарсан тохиолдолд барааг буцаан сольж захиалагчийн шаардлагад нийцсэн бараагаар сольж өгөхөө албан бичгээр ирүүлэх.

20. Тендерт оролцогч нь уг тендерт шалгарсан тохиолдолд өөрийн зардлаар, өөрийн унаагаар компанийн ажилтанаас бусад хүнээр гар дамжуулалгүй барааг хүлээн авах газарт хүлээлгэн өгч байх баталгааг албан бичгээр гаргаж ирүүлэх.

20. 2019 онд хийсэн ижил төстэй ажлын гэрээний хэрэгжилтийн талаар захиалагч байгууллагаас тодорхойлолт авч ирүүлэх.

21. Ажлын байр нь эрүүл ахуйн стандартад нийцэж байгаа эсэх талаар Мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт гаргуулсан байх. /Дүгнэлтийг 2019 оны 11 сараас хойш хийлгүүлсэн байх/

22. Тухайн тендерт оролцогч, түүний нийлүүлэх бараа нь захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолт болон стандартад нийцэж буйг нотлох баримт, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байр, агуулах гэх мэт барааг бүтэн жилийн хугацаанд тасралтгүй, гэрээний дагуу нийлүүлэх боломжтойг нотлох баримт фото зураг зэрэг холбогдох мэдээллийн хамт тусгайлан бэлтгэж ирүүлэх.

23. Тендерийн баримт бичгийн талаарх тодруулгын хариуг Төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системд байрлуулах тул тендерт оролцохыг сонирхогч этгээдүүдэд нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно. Иймд тендерт оролцохыг сонирхогч этгээдүүд дээрх цахим сайтыг байнга шалгахыг зөвлөж байна.

ТӨӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Орон нутгийн өмчийн газар 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 10 цаг 00 минутаас төрийн худалдан авах цахим системд илгээнэ үү.
ТӨӨЗ 2.2	Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газар Давхар болон өрөөний дугаар: Баянхонгор аймгийн Нутгийн удирдлагын ордон 1 давхарт 115 тоот өрөө, утас:70443224 Огноо:2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Цаг: 10 цаг 10 минут
ТӨӨЗ 2.3	Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна.
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: 3 багцтай. 1-р багц гурил гурилан бүтээгдэхүүн 6 025 450 төгрөг 2-р багц Хүнсний ногоо 2 109 550 төгрөг 3-р багц Сүү, мах махан бүтээгдэхүүн 10 873 000 төгрөг

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Техникийн тодорхойлолт бусад холбогдох бүх материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системийн ТЭЗҮ-д хавсаргав.

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжи х нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нэхцэлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгч ийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <i>[тоо]</i> жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <i>[ГТН-д заасан тоо]</i> хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| 1. Шалгах болон турших<br>(ГЕН – 1)   | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]  |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт<br>(ГЕН – 2)   | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;<br>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;<br>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;<br>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;<br>5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |  |
| 3. Баталгаат засвар<br>(ГЕН-5)  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.<br>[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.]  |
| 4. Төлбөр<br>(ГЕН – 7)  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><p>Гэрээний үнийн дүнгийн <i>[тоо]</i><sup>1</sup> хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.</p>   |
| 5. Алданги оногдуулах<br>(ГЕН - 9) <sup>2</sup>   | 9.1. Алданги оногдуулах хувь: <i>[тоо]</i><br>Алдангийн нийт дүн: <i>[тоо]</i>   |

Ихэнх тохиолдолд 100 хувь байна. Шаардлагатай бол төлбөрийн хуваарийг өөрчилнэ.

Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

## Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>3</sup>

БАТЛАВ.

### ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

### НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны сарын\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид "бараа" гэх) [гэрээний унийг тоогоор болон үсгээр] (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын\_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны дугаар сарын\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД,  
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТӨВД ХҮҮХДИЙН ХООЛ ХҮНСНИЙ МАТЕРИАЛ  
НИЙЛҮҮЛЭЛТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

**1-р багц Гурил гурилан бүтээгдэхүүн**

Д/д	Бүтээгдэхүүний нэр	Бараа бүтээгдэхүүний гаралт/усэл	Хэмжих нэгж	Л/оо ширхэг
1	Дээд гурил	Алтан тариа дүйцхүйц	кг	220
2	1-р гурил	Алтан тариа дүйцхүйц	кг	150
3	Цагаан будаа	Орос слава дүйцхүйц	кг	150
4	Шар будаа	Орос дүйцхүйц	кг	50
5	Гурвалжин будаа	Орос дүйцхүйц	кг	50
7	Элсэн чихэр	Орос дүйцхүйц	кг	80
8	Хүүхдийн будаа	Орос дүйцхүйц	кг	50
9	Ургамлын тос	Орос seatea дүйцхүйц	кг	60
10	Масло	Орос дүйцхүйц	кг	50
11	Даес	Иоджуулсан Монгол	кг	20
12	Цайны идээ	Их тайга дүйцхүйц	ш	25
13	Хөөлгөгч	Англи	кг	20
14	Сода	Орос 0.5 кг	кг	90
15	Огурцы	Орос /шилтэй.шилгүй/ дүйцхүйц	кг	30
19	Хар чавга	Орос	кг	60
20	Майонез	Орос дүйцхүйц	кг	36
21	Өндөг	Монгол	ш	800
26	Вафль печень	Орос дүйцхүйц	кг	40
28	Сармис	Монгол	кг	11
29	Чацарагана	Монгол	кг	55
30	Чихэр	Орос дүйцхүйц	кг	50
31	Алим	Орос дүйцхүйц	кг	81

**2-р багц Хүнсний ногоо**

1	Төмс	Монгол, орон нутгийн хөрсөнд ургасан шинэжилгээний бичигтэй байх	кв	1028.65
2	Байцаа	Монгол, орон нутгийн хөрсөнд ургасан шинэжилгээний бичигтэй байх	кг	283.5
3	Лууван	Монгол, орон нутгийн хөрсөнд ургасан шинэжилгээний бичигтэй байх	кг	129
4	Манжин	Монгол, орон нутгийн хөрсөнд ургасан шинэжилгээний бичигтэй байх	кг	90
5	Сонгино	Монгол, орон нутгийн хөрсөнд ургасан шинэжилгээний бичигтэй байх	кг	63

**3-р багц Сүү, мах махан бүтээгдэхүүн /Гарал үүслийн бичиг чанары/**

1	Хонины мах	Тарган 1-р зэргийн мах /Гарал үүсэл. шинжилгээний бичиг/	Кг	701
2	Үхрийн мах	Тарган 1-р зэргийн мах /Гарал үүсэл. шинжилгээний бичиг/	Кг	220
3	Шингэн сүү	Сүүний чиглэлийн үхрийн сүү /Шинжилгээний бичигтэй байх/	Кг	1200
4	Аарц	Үхрийн шар сүүгүй аарц /Шинэжилгээний бичигтэй байх/	Кг	50
5	Ааруул	Хангайн ааруул /Шинэжилгээний бичигтэй байх/	кг	45

Нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүн нь стандарт хангасан, баталгаажсан шинжилгээний бичигтэй өөрийн тээврийн хэрэгсэлээр хүргүүлэн ирүүлж байх.